АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Тариат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** АРА-2025/21/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас<br>www.Open.audit.mn<br>Архангай аймаг<br>2025 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Аудитор С.Оргил<br>Утас: 77665858<br>Цахим хаяг: Shinjlenmagadlahui.ezsh.audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.25 № 105

танай ____________-ны №____________-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ТАРИАТ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Ш.ЗОЛЗАЯА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн Тариат сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн хүрээнд нийт 12 арга хэмжээнд төсвөөс 1,274,042.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 83.5 хувь буюу 1,063,495.6 мянган төгрөгийг зарцуулж, 210,546.8 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Архангай аймгийн Тариат сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 үндсэн зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 97.5 хувьтай байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 232,980,178.06 | 291,648,033.59 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 161,033,689.31 | 216,827,283.84 |
| 311 | Кассад байгаа бэлэн мөнгө | | |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | 161,033,689.31 | 216,827,283.84 |
| 3121 | Төгрөг | 161,033,689.31 | 216,827,283.84 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 161,033,689.31 | 216,827,283.84 |
| 33 | АВЛАГА | 487,654.00 | |
| 331 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 487,654.00 | |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 71,458,834.75 | 74,820,749.75 |
| 351 | Түүхий эд материал | 26,541,538.00 | 29,609,878.00 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | 26,541,538.00 | 29,609,878.00 |
| 354 | Хангамжийн материал | 44,917,296.75 | 45,210,871.75 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 1,042,000.00 | 2,210,500.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 37,060,021.75 | 40,038,171.75 |
| 3544 | Түлш, шатах тослох материал | 5,850,000.00 | |
| 3545 | Барилгын засварын материал | | 2,750,000.00 |
| 3546 | Хүнсний материал | 965,275.00 | 212,200.00 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 553,456,578.68 | 765,021,661.41 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 553,456,578.68 | 765,021,661.41 |
| 392 | Биет хөрөнгө | 542,938,578.68 | 754,503,661.41 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 630,824,286.97 | 849,778,834.97 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -126,962,365.80 | -151,466,995.08 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 61,865,985.91 | 54,798,305.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -43,825,279.63 | -23,546,007.13 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 5,132,563.00 | 12,885,288.94 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -3,683,890.58 | -4,451,638.86 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 17,844,526.00 | 17,844,526.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | | -3,081,405.24 |
| 39217 | Ном | 1,742,752.81 | 1,742,752.81 |
| 393 | Биет бус хөрөнгө | 10,518,000.00 | 10,518,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 24,000,000.0 | 24,000,000.0 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 786,436,756.74 | 1,056,669,695.00 |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 786,436,756.74 | 1,056,669,695.00 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 786,436,756.74 | 1,056,669,695.00 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 148,749,800.92 | 148,749,800.92 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 226,283,984.48 | 496,516,922.74 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 226,283,984.48 | 226,283,984.48 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | 270,232,938.26 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 411,402,971.34 | 411,402,971.34 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 786,436,756.74 | 1,056,669,695.00 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 930,857,964.00 | 1,363,529,884.94 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 36,463,664.00 | 244,310,684.94 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 36,463,664.00 | 244,310,684.94 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 70,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 70,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 24,978,026.00 | 244,240,684.94 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 11,485,638.00 | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 894,394,300.00 | 1,119,219,200.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 810,320,700.00 | 1,036,645,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 810,320,700.00 | 1,036,645,600.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | |

| | | | |
|---|---|---|---|
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 84,073,600.00 | 82,573,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 84,073,600.00 | 82,573,600.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 764,665,760.08 | 1,093,296,946.68 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 764,665,760.08 | 1,093,296,946.68 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 750,952,106.08 | 1,076,746,486.68 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 457,818,643.82 | 722,795,730.95 |
| 210101 | Үндсэн цалин | 316,604,107.17 | 458,640,855.95 |
| 210102 | Нэмэгдэл | 122,731,354.65 | 223,576,616.00 |
| 210104 | Урамшуулал | 18,483,182.00 | 40,578,259.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 57,012,015.02 | 88,913,853.52 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,473,950.70 | 61,606,274.28 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,626,520.98 | 7,064,846.24 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,693,163.13 | 3,767,030.94 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 826,983.63 | 3,219,854.51 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,391,396.58 | 13,255,847.55 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 68,059,860.00 | 83,861,200.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,173,662.00 | 6,405,008.00 |
| 210302 | Түлш, халаалт | 65,886,198.00 | 75,974,240.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 1,481,952.00 |
| 2105 | Нормативт зардал | 93,277,800.00 | 103,040,950.00 |
| 210502 | Хоол, хүнс | 93,277,800.00 | 103,040,950.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,156,000.00 | 3,250,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,156,000.00 | 3,250,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,406,200.00 | 480,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,406,200.00 | 480,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 65,221,587.24 | 74,404,752.21 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,474,725.00 | 31,947,550.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,994,000.00 | 4,621,800.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 43,752,862.24 | 37,835,402.21 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 13,713,654.00 | 16,550,460.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 13,710,600.00 | 16,550,460.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,710,600.00 | 16,550,460.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 3,054.00 | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,054.00 | |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 166,192,203.92 | 270,232,938.26 |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 166,192,203.92 | 270,232,938.26 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 894,394,300.00 | 1,119,289,200.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 70,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 70,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 70,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 70,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 894,394,300.00 | 1,119,219,200.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 810,320,700.00 | 1,036,645,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 810,320,700.00 | 1,036,645,600.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 84,073,600.00 | 82,573,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 84,073,600.00 | 82,573,600.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 748,004,734.84 | 1,058,335,805.47 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 748,004,734.84 | 1,058,335,805.47 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 734,291,080.84 | 1,039,946,405.47 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 458,898,742.82 | 722,308,076.95 |
| 210101 | Үндсэн цалин | 314,695,023.07 | 458,153,201.95 |
| 210102 | Нэмэгдэл | 125,908,796.75 | 223,576,616.00 |
| 210104 | Урамшуулал | 18,294,923.00 | 40,578,259.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 57,012,012.02 | 88,913,853.52 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,473,950.16 | 61,606,274.28 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,626,520.74 | 7,064,846.24 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,693,162.14 | 3,767,030.94 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 826,983.38 | 3,219,854.51 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,391,395.60 | 13,255,847.55 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 78,070,546.00 | 76,573,600.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,173,662.00 | 6,405,008.00 |
| 210302 | Түлш, халаалт | 75,896,884.00 | 68,686,640.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 1,481,952.00 |
| 2105 | Нормативт зардал | 94,242,215.00 | 102,287,875.00 |
| 210502 | Хоол, хүнс | 94,242,215.00 | 102,287,875.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,000,000.00 | 6,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,000,000.00 | 6,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,406,200.00 | 480,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,406,200.00 | 480,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 38,661,365.00 | 43,383,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 34,442,800.00 | 34,188,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,218,565.00 | 9,194,700.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 13,713,654.00 | 18,389,400.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 13,710,600.00 | 18,389,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 13,710,600.00 | 18,389,400.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 3,054.00 | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,054.00 | |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 146,389,565.16 | 60,953,394.53 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | | |
| | Дотоод эх үүсвэрээр | | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 5,159,800.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | | -5,159,800.00 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 146,389,565.16 | 55,793,594.53 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 161,033,689.31 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 216,827,283.84 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 148,749,800.92 | 411,402,971.34 | 60,091,780.56 | 620,244,552.82 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 148,749,800.92 | 411,402,971.34 | 60,091,780.56 | 620,244,552.82 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 166,192,203.92 | 166,192,203.92 |
| C08 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 148,749,800.92 | 411,402,971.34 | 226,283,984.48 | 786,436,756.74 |
| D01 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 148,749,800.92 | 411,402,971.34 | 226,283,984.48 | 786,436,756.74 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 148,749,800.92 | 411,402,971.34 | 226,283,984.48 | 786,436,756.74 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 270,232,938.26 | 270,232,938.26 |
| D09 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 148,749,800.92 | 411,402,971.34 | 496,516,922.74 | 1,056,669,695.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Харь-цуулалт |
|---|---|---|---|---|---|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,274,042,400.00 | 1,063,495,605.47 | 210,546,794.53 | 83.47 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,274,042,400.00 | 1,063,495,605.47 | 210,546,794.53 | 83.47 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,255,653,000.00 | 1,045,106,205.47 | 210,546,794.53 | 83.23 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 901,981,200.00 | 722,308,076.95 | 179,673,123.05 | 80.08 |
| 210101 | Үндсэн цалин | 614,351,000.00 | 458,153,201.95 | 156,197,798.05 | 74.58 |
| 210102 | Нэмэгдэл | 260,978,800.00 | 223,576,616.00 | 37,402,184.00 | 85.67 |
| 210104 | Урамшуулал | 26,651,400.00 | 40,578,259.00 | -13,926,859.00 | 152.26 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 102,816,600.00 | 88,913,853.52 | 13,902,746.48 | 86.48 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 69,917,800.00 | 61,606,274.28 | 8,311,525.72 | 88.11 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,222,800.00 | 7,064,846.24 | 1,157,953.76 | 85.92 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,112,600.00 | 3,767,030.94 | 345,569.06 | 91.6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,112,600.00 | 3,219,854.51 | 892,745.49 | 78.29 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,450,800.00 | 13,255,847.55 | 3,194,952.45 | 80.58 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 76,573,600.00 | 76,573,600.00 | | 100 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,339,500.00 | 6,405,008.00 | -65,508.00 | 101.03 |
| 210302 | Түлш, халаалт | 63,334,100.00 | 68,686,640.00 | -5,352,540.00 | 108.45 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,900,000.00 | 1,481,952.00 | 5,418,048.00 | 21.48 |
| 2105 | Нормативт зардал | 112,946,200.00 | 102,287,875.00 | 10,658,325.00 | 90.56 |
| 210502 | Хоол, хүнс | 112,946,200.00 | 102,287,875.00 | 10,658,325.00 | 90.56 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,000,000.00 | 6,000,000.00 | | 100 |
| 210604 | Урсгал засвар | 6,000,000.00 | 6,000,000.00 | | 100 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,078,100.00 | 480,000.00 | 2,598,100.00 | 15.59 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,078,100.00 | 480,000.00 | 2,598,100.00 | 15.59 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 52,257,300.00 | 48,542,800.00 | 3,714,500.00 | 92.89 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 43,062,600.00 | 39,348,100.00 | 3,714,500.00 | 91.37 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,194,700.00 | 9,194,700.00 | | 100 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 18,389,400.00 | 18,389,400.00 | | 100 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 18,389,400.00 | 18,389,400.00 | | 100 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 18,389,400.00 | 18,389,400.00 | | 100 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,274,042,400.00 | 1,119,289,200.00 | 154,753,200.00 | 87.85 |
| 131 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,036,645,600.00 | 1,036,645,600.00 | | 100 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,036,645,600.00 | 1,036,645,600.00 | | 100 |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 82,573,600.00 | 82,573,600.00 | | 100 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 82,573,600.00 | 82,573,600.00 | | 100 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 154,823,200.00 | 70,000.00 | 154,753,200.00 | 0.05 |
| | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 70,000.00 | -70,000.00 | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 154,823,200.00 | | 154,823,200.00 | |
| 124 | БУСАД ЭХ ҮҮСВЭР | | | | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 161,033,689.31 | -161,033,689.31 | |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 216,827,283.84 | -216,827,283.84 | |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | | 100 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | | 100 |
| 5 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 33 | 33 | | 100 |
| 6 | Удирдах ажилтан | 2 | 2 | | 100 |
| 7 | Гүйцэтгэх ажилтан | 19 | 19 | | 100 |
| 8 | Үйлчлэх ажилтан | 12 | 12 | | 100 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа[1] илрээгүй бөгөөд нийт **1,544.0** мянган төгрөгийн зөрчил[2] илэрсэн зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага, ажил гүйлгээний ангитай холбоотой зөрчил[3] илэрсэн бөгөөд зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ

Аудитаар залруулагдаагүй 1 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь **1,544.0** мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн **14,332.9** мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

### 3.1. Төлбөрийн акт

**3.1.1.** Тэтгэвэрт гаргасан 1 албан хаагчийг үндсэн ажилтнаар ажиллуулж 1,544.0 мянган төгрөгийн албан хаасан хугацааны нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Төрийн албан тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.2-т “Тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн”, 46.2.3-т “Төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 зүйлийн 14.3.1-д “Анхан шатны баримт бүрдүүлэх”, 20 зүйлийн 20.2.4-т “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах, гэсэн заалттай нийцэхгүй байна.

20.2.4.нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;

### 3.2. Зөвлөмж

_Илрүүлэлт:_ Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/273 дугаар тушаалын хавсралтаар баталсан жагсаалтын дагуу эцэг, эх, асран хамгаалагчдаас хүлээн авсныг нягтлан бодох бүртгэл, тайланд тусгаагүй байна.

_Илрүүлэлт:_ Нягтлан бодох бүртгэлийн цахим программыг өдөр тутмын ажил гүйлгээнд ашиглаагүй, бараа материалын зарлагын гүйлгээнүүдийг нэгтгэж сарын сүүлийн өдөр

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

[3] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

программд оруулсан, анхан шатны баримтыг программаар боловсруулаагүй гар аргаар хөтөлсөн байна.

Энэ нь Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4, 16 дугаар зүйлийн 16.5.7 дахь заалттай нийцэхгүй байна.

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.*

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Алба хаасан хугацааны нэмэгдэл | 1 | 1,544.0 | 1 | 1,544.0 | | | | | | | | |
| Санхүүгийн программ | 1 | | | | | | 1 | | | | | |
| Бараа материал | 1 | | | | | | 1 | | | | | |
| **Нийт дүн** | **3** | | **1** | **1,544.0** | | | **2** | | | | | |